

Хөгжилтэй бяцхан үрсээсээ хүүхэд насыг нь бүү булаагаарай

Хүүхдийн эрх хамгаалал төв

Л.Бадамцэцэг

Хүүхдийн сэтгэл зүйч

Хүний амьдралын үнэ цэнэтэй холбоотой нийтлэл, сурвалжлага, асуудал хөндсөн нэвтрүүлгээр ТА юуг харуулахыг зорьдог вэ? Яах гэж?

- Болсон явдлаар шуугиан дэгдээж, нийгмийг сэрээх гэж үү? **Танин мэдэхүй, сонирхол уу?**
- Болсон явдлаар шуугиан дэгдээж, нийгмийг сэрээх гэж үү? **Сэрэмжлүүлэг үү? Хэнд?**
- Болсон явдлаар шуугиан дэгдээж, нийгмийг сэрээх гэж үү? **Тогтолцоог хөндөх үү?**
- Болсон явдлаар шуугиан дэгдээж, нийгмийг сэрээх гэж үү? **Хувь хүнийг олны танил болгох уу?**

" Яагаад?" гэж бүү асуу

Хүүхдийн эрхийн зөрчил, хүчирхийлэл нь

- сайн сайхан хүсэл мөрөөдөл
- өөртөө итгэх итгэл, эрхэм чанар
- амьдралын баяр баясгаланг *үгүй хийж*
- эрүүл мэндийг нь хохироож
- амь насанд нь аюул учруулж
- байнгын занал сүрдүүлэг дор аймшигт мөчүүдийг *сэтгэл түгшин өнгөрөөхөд хүргэдэг.*

Хүчирхийлэл ба эрхийн зөрчил нь сөрөг харилцаа

Хүчирхийлэл үйлдэгчийн зан байдал нь

- Бусдыг дорд үзэн , басамжлах
- Гутаан доромжилж биеийн болон сэтгэл санааны дарамт, шаналгаанд оруулах нь хохирогчдын хувьд гутамшигт явдал мэт санагдаж, гомдож, гутран, сэтгэл санааны хямралд ордог.
- Хүчирхийлэл үйлдэгчийн үйлдлийг түр ч атугай зогсоохын тулд гэр бүлийн бусад гишүүд аргагүйн эрхэнд хүсэл сонирхолд нь нийцүүлэхийг хичээдэг болно.

Гэр бүлийн нууц

- Хүчирхийллийн харилцаатай эцэг эхийн хэн ч хүүхдээ анзаарах сөхөөгүй байдаг.
- Аль ч насны хүүхэд "Гэр бүлийнхээ нууц"-аа хэлэхийг хүсдэггүй.
- Хүүхдийн дотроо юу бодож байгааг сэтгэлийн хөдөлгөөний илрэл, нүүр царайны хувирал, үйл хөдлөлөөс нь / биеийн хэлэмж/ харж болно.

" Яагаад?" гэж бүү асуу

- Гэр бүл дэх хүчирхийлэл дарамтанд өртсөн эхчүүд, хүүхдүүдээс яагаад ийм байдалд хүрсэн шалтгааныг бүү асуу.**
- Учир нь "Яагаад?" асуулт нь түүнийг буруутгаж байгаа мэт мэдрэмж төрүүлдэг.**

"Гэр бүлийн нууц"-аараа үлдэх үү...?

- *ГБХ-д өртөгсөд хүчирхийллийг зүгээр л хараад өнгөрөөх биш, харин сэтгэлээ хуваалцаж, бие биедээ итгэх нь чухал байдаг.*
- *...Би эцэг эх хоёрынхоо дунд болж байгаа бүх зөрчил маргааныг сонсож, хардаг байсан. Ээж надад итгэж, дотночлон хандах хүртэл " ээж аавын хэлснээр л хичээж байхад яагаад дандаа ингэдэг юм бол доо " гэж боддог байлаа...*

/ Ээжтэйгээ хамт хамгаалах байранд байрлаж байсан 14 настай охины ярианаас/

Хүчирхийллийн харилцаатай гэр бүл хүүхдээ золиосолдог

- Гэр бүлдээ хүчирхийлэл үйлддэг эцгүүд ээжийнх нь "хэрүүлч"-ээс болж асуудал үүсдэг, өөрөө ямар ч буруугүй гэж хүүхэддээ итгүүлэхийг хичээдэг. Энэ үгийг нь батлах мэт ээж нь уураа хүүхэддээ гаргадаг нь чухам хэн нь буруутай вэ гэдэгт хүүхдийг эргэлзэхэд хүргэдэг.
- ***Хүүхэд эцэг эхийн хоорондын тэмцлийг болиулахын тулд тэдний гарт өртөж, биеийн хүчний, сэтгэл санааны тэр ч байтугай үл хайхрах шоовдорлох хэлбэрийн хүчирхийлэлд өртдөг.***
- ***Хүүхэд хүчирхийлэлд өөрийгөө буруутгадаг.***
- ***Зан үйлд нь өөрчлөлт ордог.***
- ***Эрүүл мэндийн асуудал нь орхигддог***
- ***Аюулгүй байдал нь алдагддаг .***
- ***Хүүхдийг барьцаалдаг.***
- ***Хүүхдийг өөрийг нь хүчирхийлж дарамталдаг.***
- ***Зарим гэр бүлд хүүхэд нь бэлгийн хүчирхийллийн хохирогч болдог.***

Хүүхдүүд хүчирхийллийн гэрч болдог

- **Хүүхэд амсаж өнгөрүүлсэн зовлонгоо өөрийнхөө бүтээл, тоглоомдоо гаргаж харуулдаг. /**
Хүүхдийн зурсан зураг , тоглоомыг харахад тэдний туулж өнгөрүүлсэн амьдралын тухай дурсамж харагддаг./

Хүчирхийлэлд хүүхэд буруугүй

- Гэр бүл дэх хүчирхийлэл, дарамтанд өртөж байсан хүүхэдтэй ярилцаж зөвлөгөө өгөхдөө өөрийг нь буруутгахгүй, ичээхгүйгээр чөлөөтэй ярих боломж олгон, итгэж байгаагаа илэрхийлэх нь чухал.
- зарим хүүхэд том болох тусмаа маш уйтгартай, гөлрөнги, сэтгэлийн хөдөлгөөн нь дотогшоо, дуу шуу муутай болох
- зарим нь бүр эсрэгээр түрэмгий, сахилгагүй болох
- Зарим хүүхэд дэндүү эрт өөрийгөө том хүн болсон гэж үзэж, өөртөө хэтэрхий их үүрэг хариуцлага ноогдуулдаг.
- Зарим хүүхэд сэтгэлийн их хөөрөлд автаж, зөвхөн өөрт байгаа нөөц боломжиндоо л итгэж, томчуулд итгэдэггүй
- Нийгмийн сөрөг үр дагаврын түүхийг бүтээгч нэгэн болж болзошгүй

Хүүхдүүд гэр бүл дэх хүчирхийллийг харж өсснөөр зөрчил зөрөлдөөнийг шийдвэрлэх ухаалаг арга замыг олохоосоо илүү занал сүрдүүлэг, хүч хэрэглэж өөрийн эрх мэдлээ тогтоох зэрэг хүчирхийллийн үйлдлүүдийг сурч авдаг.

Үр дагавар

- Гэрээсээ дайжих / гэр бүлээсээ ойлголцол итгэл олж чадаагүй учир гудамжнаас эрэх чөлөө ойлголцол хайж/
- Худлаа хэлэх
- Гэмт хэрэгт холбогдох
- Сургууль завсардах
- Амиа хорлох
- Түрэмгий зан авиртай болох
- Өөрийгөө дорд үзэх, өөрийн үнэлэмж буурах,
- Харилцааны зөрчил

Энэ сэдвээр гол өгөх мессеж бол :

- Хүчирхийллийн харилцаа нь хүүхдэд хэрхэн нөлөөлдөг вэ?
- “ Та хүүхдээ чихээрээ биш, хонгоороо сонсдог хүн болгохыг хүсч байна уу?” / Эцэг эхийн үлгэр дуурайл /
- Хүчирхийлэл үүсэх шалтгаан .Гол шалтгаан бол үзэл бодол, дараа нь нийгмийн шалтгаанууд /сөрөг үзэгдлүүд/
- Хүмүүжлийн арга, шийтгэл хүчирхийллийн ялгаа
- Нийгмийн аль ч давхаргад хүчирхийлэл байдаг тухай / өрөөсгөл гэр бүлд амьдардаг хүүхдүүд л хүчирхийлэлд өртдөг гэсэн олон нийтийн үзэл хандлагыг өөрчлөх / өнчин юм уу, хойд эцэг эхтэй хүүхэд, мөн архичин, ядуу гэр бүлд илүү байдаг гэсэн ойлголтыг няцаах,
- Хүчирхийлэлд өртсөн хүүхдэд үзүүлэх тусламж, дэмжлэг
- Хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх арга замууд
- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн зарим зохицуулалт
- Төрийн хүчирхийлэл

Хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх:

- Гэр бүлийн халуун дулаан уур амьсгал
- Хүүхдээ хүндэтгэж харьцах
- Гэр бүлийн маргаан зөрчлөө эцэг эхчүүд аль болох хүүхдийн нүдэн дээр ил гаргахгүй байх
- Хүүхэдтэйгээ чин сэтгэлээсээ илэн далангүй ярилцах, дотны найз нь байх. Бид материаллаг хэрэгцээг нь хангаж өгснөөр халамж анхаарлаа тавьж байна гэж боддог. Гэтэл тэдний дотоод сэтгэлд юу дутагдаж, үгүйлэгдэж байна вэ гэдгийг тэр болгон мэддэггүй. Энэ бол маш чухал.
- Хүүхдийн алдааг уучлах, алдааг нь өсгөж ярих юм уу, гаргасан алдааг нь шийтгэхээс өмнө болно, болохгүйн учрыг тайлбарлан ярилцаж, ойлгуулах
- Хүүхдээр өөрөөр нь сонголт хийлгэх
- Хүүхдийн эсрэг хүчирхийллийн үр дагаврыг олон нийтэд ойлгуулах
- Хүүхдийн эсрэг хүчирхийллийг нийтээрээ эсэргүүцдэг нийгмийн сэтгэл зүйг бий болгон төлөвшүүлэх
- Тогтолцоотой холбоотой зарим асуудлыг хөндөх, эргэн сурвалжлах боломж

- Амжилт хүсье